

**““ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК, “МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ХХК-ИЙН
ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” ТОГТООЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахад энэ тогтоолын зорилго оршино.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Энэ үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн зургаан шалгуур үзүүлэлтээс дараах дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Тогтоолын төслийн нэгдүгээр зүйлд: ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтын “суутган тооцох хэлцэл хийж” гэснийг “суутган тооцож” гэж өөрчилнө.

2.Ойлгомжтой байдал:

Хуулийг дагаж мөрдөх, хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой байгаа эсэх, хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд уялдаатай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбар байгаа эсэхийг тогтоох зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

**ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ
ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
-----	------------------	------------------------	-----------------

1	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Тогтоолын төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийг тухай хуульд заасан аргачлалд нийцсэн эсэхийг нягтлах. Хэрэгжүүлэхэд хялбар байх эсэхийг тодруулах

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1.Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

Тогтоолын төсөл батлагдсанаар ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах боломжтой болно.

2. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Тогтоолын төслийн нэгдүгээр зүйлд: ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтын “суутган тооцох хэлцэл хийж” гэснийг “суутган тооцож” гэж өөрчилнө.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт

Тогтоолын төсөл батлагдсанаар ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах боломжтой болно.

САНГИЙН ЯАМ